



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/130

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, 24 дүгээр зүйлийн 24.1.5, 25 дугаар зүйлийн 25.2 дахь заалтад заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгаас хамгаалах Удирдах албан тушаалтны сургалтын хөтөлбөр, сэдэвчилсэн төлөвлөгөөг нэгдүгээр, Мэргэжлийн ангийн сургалтын хөтөлбөр сэдэвчилсэн төлөвлөгөөг хоёрдугаар, Ажилтан, албан хаагчдын сургалтын хөтөлбөр, сэдэвчилсэн төлөвлөгөөг гуравдугаар, Сайн дурынханд гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын хөтөлбөр, сэдэвчилсэн төлөвлөгөөг дөрөвдүгээр, Иргэдэд гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын хөтөлбөр, сэдэвчилсэн төлөвлөгөөг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан хөтөлбөр, сэдэвчилсэн төлөвлөгөөний дагуу гамшгаас хамгаалах сургалтыг орон нутаг, нэгжид зохион байгуулж явуулахыг Онцгой байдлын ерөнхий газрын харьяа салбар, нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Батлагдсан гамшгаас хамгаалах сургалтын хөтөлбөр, сэдэвчилсэн төлөвлөгөө, хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөмжийг орон нутгийн онцгой комисс, мэргэжлийн анги, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад хүргэж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга нарт даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2007 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 81 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Т.БАДРАЛ

0006573

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2016 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн
А/30 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, СЭДЭВЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

ЗОРИЛГО

Аймаг, нийслэл, сум /дүүрэг/, баг, хороо, улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба, аж ахуйн нэгж, байгууллагын удирдах албан тушаалтанд хүн, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчноо гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны онолын мэдлэгийг олгож дадлагажсанаар хүн амыг сургаж бэлтгэх, улмаар дээрх ажлыг удирдан зохион байгуулах чадвар, дадал олгоход оршино.

ЗОРИЛТ

- Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд удирдах албан тушаалтныг сургаж дадлагажуулах,

- Гамшгаас хамгаалах удирдах албан тушаалтны сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх,

- Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг нэмэгдүүлэх,

- Сургалтын агуулгыг Онцгой байдлын албанаас тавьж буй зорилт, шаардлагатай нийцүүлэн боловсронгуй болгох,

- Аюулт үзэгдэл, ослын төрөл бүрд урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах талаар онол, практикийн мэдлэг, чадвартай удирдах албан тушаалтныг бэлтгэх.

ХАМРАХ ХҮРЭЭ

Аймаг, нийслэл, сум /дүүрэг/, баг /хороо/-ийн удирдлага, улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах албадын удирдлага, аж ахуйн нэгж, байгууллагын удирдах албан тушаалтан хамрагдана.

Гамшгаас хамгаалах улсын албаны удирдах албан тушаалтны сургалтыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум /дүүрэг/, баг /хороо/, гамшгаас хамгаалах орон нутгийн алба, аж ахуйн нэгж байгууллагын гамшгаас хамгаалах албаны удирдах албан тушаалтны сургалтыг төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс тус тус хариуцан зохион байгуулна.

ХУГАЦАА

Гамшгаас хамгаалах удирдах албан тушаалтны сургалтыг хоёр жилд нэг удаа зохион байгуулна.

---oOo---

ГАМШГААС ХАМГААЛАХ УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Хүлээгдэж буй ерөнхий үр дүн:

- Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндсүүдийг мэдэх, үйл ажиллагаандаа ашиглаж сурах,
- Аюулт үзэгдэл, ослын талаар ерөнхий ойлголттой болж, түүнээс урьдчилан сэргийлэх мэдлэгийг дээшлүүлэх,
- Аюулт үзэгдэл, ослын үед иргэдийн амь нас, улс, нийгмийн өмч хөрөнгийг аврах, хамгаалах арга ажиллагаанд удирдах албан тушаалтныг сургаж бэлтгэх,
- Аюулт үзэгдэл, ослоос хүн ам, эд хөрөнгө, хүрээлэн буй орчныг урьдчилан сэргийлэх талаар удирдах албан тушаалтны мэдлэг, чадвар, хандлагыг дээшлүүлэх,
- Аюулт үзэгдэл, ослын үед удирдлага, зохион байгуулалтаар хангах мэдлэг, дадлага, чадвараа нэмэгдүүлэх,
- Гамшгийн аюул ослын үед удирдах албан тушаалтны гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны харилцан уялдаа холбоо сайжрах.

Зорилт	Хүлээгдэж буй үр дүн	Мэдлэг	Аюулгө Чадвар	Хэрэглээ/ хандлага
Гамшгаас хамгаалах удирдах албан тушаалтан, албан хаагчдын эрхэлж буй албан тушаалын зэрэглэл, шатлалын хүрээнд хүн, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчноо гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, эдгээр үйл ажиллагааны онолын мэдлэгийг бататгаж, хүн амыг сургаж бэлтгэх, улмаар дээрх ажлыг удирдан зохион байгуулах чадвар, дадал олгох	-Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах мэдлэг, чадвартай болох	- Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндэс, Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө - Аюулт үзэгдэл, ослын тухай ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх - Гамшгийн үеийн шуурхай удирдлага, зохион байгуулалт, штабын бэлтгэл - Гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох - Ангиллын сургалтыг зохион байгуулах арга зүй	- Байгууллага, ард иргэдэд гамшгаас хамгаалах талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх - Үүссэн гамшиг ослын үед бэлтгэл, бэлэн хангах, чиг үүрэг өгөх, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах - Ангиллын сургалтыг зохион байгуулах	-Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад хууль, эрх зүйн баримтыг үйл ажиллагаандаа ашиглах -Үүссэн гамшиг ослын үед бэлтгэл, бэлэн байдлыг хангах, чиг үүрэг өгөх, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах - Ангиллын сургалтын чанар, хүртээмжийг дээшлүүлэх

ГАМШГААС ХАМГААЛАХ УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫ СУРГАЛТЫН СЭДЭВЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Агуулга	Сэдэв	Сургалт зохион байгуулах хэлбэр, цаг			
			лекц	семинар	Даллага, дүгнэлт	нийт
Сургалтын агуулгын төрөл: Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндэс (2 цаг)						
1	Хууль тогтоомж, эрх зүйн акт	<ul style="list-style-type: none"> - Гамшгаас хамгаалах тухай хууль, - Галын аюулгүй байдлын тухай хууль, - Нөөцийн тухай хууль болон бусад хууль, тогтоомж, - Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөр, дүрэм, журмууд, тэдгээрийн шинэчлэл 	2			2
Бүгд						
Сургалтын агуулгын төрөл: Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө						
2	Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө	<ul style="list-style-type: none"> - Улс болон аймаг, нийслэл, сум, дүүрэг, аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө - Үндэсний болон олон улсын чиг хандлага 	2		2	4
Бүгд						
Сургалтын агуулгын төрөл: Аюулгүй байдлын осолын тухай үндэсний боллого (12 цаг)						
3	Гамшгийн төрлүүд, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах,	<ul style="list-style-type: none"> - Газар хөдлөлт, хөрсний гулсалт - Ой хээрийн түймэр - Үер - Хүн, мал, амьтны гоц халдварт өвчин - Цасан болон шороон шуурга - Ган, зуд, цөлжилт - Үйлдвэрлэлийн болон техникийн холбогдолтой осол - Цацраг идэвхт бодис болон ХУХБ-ын аюул - Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, дэлбэрэлт 	2	4	6	12
Бүгд						
			2	4	6	12

4	Гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалт, штабын бэлтгэл	<ul style="list-style-type: none"> - Гамшиг ослын үеийн арга хэмжээ <ul style="list-style-type: none"> ▪ Өгсөн үүрэг, чиглэлтэй танилцах ▪ Цагийн байдлыг үнэлэх ▪ Шийдвэр гаргах ▪ Цагийн байдлыг зурагт оруулах ▪ Үүрэг хүргэх, тавих ▪ Урьдчилан сэргийлэх, аврах ажлыг төлөвлөх ▪ Харилцан ажиллагааг зохион байгуулах ▪ Бүх төрлийн хангалтыг зохион байгуулах ▪ Явцыг удирдах, хяналт шалгалтыг зохион байгуулах ▪ Тайлан мэдээ гаргах - Гамшиг ослын үед оролцох байгууллагууд, чиг үүрэг, хүч хэрэгсэл - Сэргээн босгох арга хэмжээ 	6	6	12
БҮГД					
5	Гамшгаас хамгаалах ангиллын сургалт зохион байгуулах арга зүй	<ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн анги - Ажилтан, албан хаагч - Ард иргэд 	2	4	6
БҮГД					

---000---

ГАМШГААС ХАМГААЛАХ УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх болсон хэрэгцээ, шаардлага

Монгол Улсын хэмжээнд тохиолдож байгаа аюулт үзэгдэл, ослын тоо, давтамж нэмэгдэж, хүний амь эрсдэн, хүрээлэн буй орчин, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд учруулах хохирол буурахгүй байна. Улсын хэмжээнд аюул, ослоос аврах, хамгаалах хүч хэрэгсэл дутмаг, мэргэжлийн байгууллага, иргэд гамшгаас хамгаалах аргад бүрэн сургаж бэлтгэгдээгүй байгаа нь өнөөгийн эрэлт хэрэгцээ, шаардлагад хүрэхгүй нь ойлгогдож байна.

2003 онд батлагдсан Гамшгаас хамгаалах тухай хуулиар гамшгаас хамгаалах сургалтыг ангилан зохион байгуулж явуулах талаар заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2007 оны 81 дүгээр тушаалаар ангиллын сургалтын хөтөлбөрийг баталсан. 2007 оны 81 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад тодорхойлсон гамшгаас хамгаалах удирдах ажилтны сургалтын агуулга нийт 224 цагийн багтаамжтай байгаа нь сургалтыг зохион байгуулахад цаг хугацаа, хөрөнгө зардал их шаардагдаж хэрэгжихэд хүндрэлтэй байгаа юм. Иймд өнөөдрийн байдлаар уг сургалтын хөтөлбөр батлагдаад удсан боловч хэрэгжээгүй, зарим төрлийн аюулт үзэгдэл, осол нэмэгдсэн, гамшгаас хамгаалах алба, төрөл өөрчлөгдсөн зэрэг нь сургалтын хөтөлбөрийг шинэчлэн хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

Сургалт явуулах эрх зүйн үндэс

Гамшгаас хамгаалах тухай хуулийн

- 7 дугаар зүйлийн 7.2-т “Гамшгаас хамгаалах сургалтыг удирдах албан тушаалтны, аврах анги, отряд салбар, мэргэжлийн ангийн, оюутан сурагчдын, ажилтны, бусад иргэний гэсэн ангиллаар явуулна”,

- 7.3-т Гамшгаас хамгаалах сургалтыг дараах байгууллага, албан тушаалтан хариуцаж зохион байгуулна: 7.3.1 “... гамшгаас хамгаалах албаны удирдах бүрэлдэхүүний сургалтыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага”, 7.3.2-т сум, дүүрэг, аж ахуйн нэгж байгууллагын гамшгаас хамгаалах албаны удирдах бүрэлдэхүүн, мэргэжлийн ангийн дарга, дүйцүүлэх алба хааж байгаа иргэдийн сургалтыг аймаг, нийслэлийн гамшгаас хамгаалах алба, штаб” гэж,

- Мөн хуулийн 18 дугаар зүйлд Гамшгаас хамгаалах улсын албаны нийтлэг чиг үүрэг,

- 27 дугаар зүйлд Аж ахуйн нэгж байгууллагын хүлээх үүрэгт, мөн МУ-ын Их хурлаар 2011 онд баталсан “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого”-д “...хүн амыг аюулгүй амьдрах ухаанд сургах...” гэж,

- Засгийн Газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор баталсан “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрт”...гамшгийн эрсдэлийг бууруулах олон нийтийн сургалт, сурталчилгааг бүх түвшинд шат дараалан зохион байгуулах...” гэж тус тус заасан байдаг.

Агуулгын зөвлөмж

Гамшгаас хамгаалах удирдах ажилтанд зориулан боловсруулсан гамшгаас хамгаалах мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр нь:

1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндэс, Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө,
2. Аюулт үзэгдэл, ослын тухай ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх,
3. Гамшгийн үеийн шуурхай удирдлага, зохион байгуулалт, штабын бэлтгэл,
4. Гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох,

5. Ангиллын сургалтыг зохион байгуулах арга зүй гэсэн 5 агуулгын хүрээнд, хүлээгдэж буй үр дүнг агуулгын хүрээ тус бүрийн харгалзах чадамжид үндэслэн, зайлшгүй мэдэх суурь ойлголтуудыг олгохоор сонгосон болно.

Удирдах ажилтны сургалтыг зохион байгуулахдаа тухайн аймаг, орон нутгийн байгаль, газар зүйн онцлог, цаг агаарын нөхцөл, зонхилон тохиолддог аюулт үзэгдэл, гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн алба байгууллагын онцлог, хүчин чадал, нөөц бололцоог харгалзан үзэх нь зүйтэй.

Нэгж болон ээлжит хичээлийн төлөвлөлтийг хийхдээ:

- зорилго зорилтоо оновчтой тодорхойлох,
- хөтөлбөрийн дагуу агуулгаа боловсруулах,
- хөтөлбөр дэх агуулгын холбоо хамаарлыг зөв гаргах,
- агуулга залгамж холбоотой, сонголттой, уян хатан байх зарчмуудыг баримтална.

Арга зүйн зөвлөмж

Хөтөлбөрийн хүлээгдэж буй үр дүнд хүрэхэд шаардлагатай мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшүүлэхийн тулд онол, дадлагыг хослуулан сургалтыг зохион байгуулна. Гамшгаас хамгаалах удирдах ажилтанд зориулсан сургалтын 20 хувь нь онол, 80 хувь нь дадлага буюу биеэр хийж гүйцэтгэх ажил байж сургалтын шинэлэг, үр дүнтэй аргуудыг хэрэглэх шаардлагатайг багш нарт зөвлөж байна. Сургалтын онцлогоос хамааран хөтөлбөрт тусгагдаагүй зарим сэдвийг нэмж оруулан нийт цагийн багтаамжийн 20 хүртэлх хувийг өөрчлөн зохион байгуулж болно.

Сургах арга барил нь суралцагсдын ажлын туршлага, үйл ажиллагааны онцлог, бодит нөөц боломжид тулгуурласан байна.

Сургалтын үйл ажиллагааг бүлэг сэдэв тус бүрээр үнэлгээ хийж цаашид зохион байгуулах сургалт болон гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хэрэгжүүлэх санал, дүгнэлт, зөвлөмжийг хэлэлцүүлнэ.

Хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрт заасан сургалтыг явуулахдаа онолын хичээлд ном, сурах бичиг, зурагт хуудас, фото зураг, кино, цахим үзүүлэн, богино хэмжээний бичлэг ашиглан багш, суралцагсад хамтран явуулах нь үр дүнд хүрнэ. Үүний тулд сургагч багш хичээлд сайн бэлдэж томъёоллоо зөв олж сурах хэрэгтэй.

Сургалтыг явуулахдаа ашиглах хэрэглэгдэхүүнийг багш орон нутгийн бололцоо, боломжид тулгуурлан боловсруулж, бэлтгэхээс гадна гамшгаас хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн байгууллага, өөрийн харьяалах байгууллагаас мэргэжлийн зөвлөгөө дэмжлэг авч, шаардлагатай хэрэглэгдэхүүнээр хангагдана.

---oO---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2016 оны 5 дугаар сарын 10 ны өдрийн
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

A/30



ГАМШГААС ХАМГААЛАХ ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН БҮЛГҮҮДЭД ГАМШГААС ХАМГААЛАХ МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

ЗОРИЛГО

Бие бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, бэлэн байдлыг дээшлүүлэх замаар өнөөгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, мэргэжлийн түвшинд үйл ажиллагаа явуулах мэдлэг, чадвар бүхий тусгай чиг үүргийн бүлгийг бий болгоход сургалтын хөтөлбөрийн зорилго оршино.

ЗОРИЛТ

- Гамшгаас хамгаалах тусгай чиг үүргийн бүлгийн сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх,
- Сургалтын агуулгыг Онцгой байдлын албанаас тавьж буй зорилт, шаардлагатай нийцүүлэн боловсронгуй болгох,
- Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн чадавхийг бэхжүүлэх,
- Аюулт үзэгдэл, ослын төрөл бүрд урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах талаар онол, практикийн мэдлэг, чадвартай мэргэжлийн ангийг бэлтгэх.

ХАМРАХ ХҮРЭЭ

Мэргэжлийн ангийн дүрэмд заасан Ерөнхий зориулалтын болон Тусгай зориулалтын мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн хамрагдана.

ХУГАЦАА

Гамшгаас хамгаалах тусгай чиг үүргийн бүлгийн бие бүрэлдэхүүний сургалтыг жил бүр явуулна.

---oOo---

**ГАМШГААС ХАМГААЛАХ ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН БҮЛГИЙН БҮРЭЛДЭХҮҮНД
ГАМШГААС ХАМГААЛАХ МЭДЛЭГ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Сургалтын агуулгын төрөл, цаг	Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндэс	Аюулт үзэгдэл, ослын тухай ойлголт	Гамшгаас урьдчилан сэргийлэх	Эрэн хайх, аврах ажиллагаа	Хор уршгийг арилгах, сэргээн босгох	Нийт цаг
Мэргэжлийн ангийн нэр						
Ерөнхий зориулалтын	7	6	13	24	10	60
Эмнэлгийн яаралтай тусламжийн	7	6	10	33	7	63
Хээрийн эмнэлэг	7	6	10	33	7	63
Цус сэлбэх хөдөлгөөнт	7	6	10	33	7	63
Хөдөлгөөнт эмийн сан	7	6	10	33	7	63
Эмнэлэг эрүүл ахуй, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх	7	6	10	33	7	63
Хүүхэд хамгааллын	1	2	10	17	6	36
Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах	1	2	10	17	6	36
Гал унтраах	7	6	2	34	7	65
Дулааны шугам сүлжээний засварын	1	-	3	25	5	34
Цэвэр, бохир усны засварын	1	-	1	15	5	22
Цахилгааны шугам сүлжээний засварын	1	-	3	12	5	21
Зам, гүүрийн засварын	1	-	3	15	5	24
Инженер тэсэлгээний ажлын	1	-	3	15	5	24
Хэв журам сахиулах, харуул хамгаалалтын	7	7	13	18	6	51
Тусгай бүлэг	2	2	4	8	3	19
Цацраг, химийн хяналтын	1	-	-	19	3	23
Ургамал, газар тариалан хамгаалах	7	6	2	28	3	46
Мал эмнэлгийн нарийн мэргэжлийн хөдөлгөөнт	7	6	2	28	3	46
Санхүү, нийгмийн хамгааллын	2	-	1	8	9	20
Хүнсний хангалтын	3	1	1	16	8	29
Нөөцийн материал, орон сууцны хангалтын	3	1	1	16	8	29
Уст цэг хамгаалах	1	-	4	13	3	21
Цугларах байрны	3	1	1	16	8	29
Шатахуун хангалтын	3	1	1	16	8	29
Тээврийн	3	1	1	16	8	29
Ариутгал, халдваргүйжүүлэлтийн	1	2	2	8	3	16
Холбоо, зарлан мэдээллийн	1	2	2	8	-	13
Сурталчилгаа, мэдээллийн	1	-	2	6	2	11
Иргэнийбүртгэл, мэдээллийн	1	-	2	6	2	11
Төмөр замын техникийн засварын	2	-	2	11	8	23
Нисэх буудлын авран туслах	2	-	2	11	8	23

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН БҮЛГИЙН БҮРЭЛДЭХҮҮНД ГАМШГААС ХАМГААЛАХ МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Хүлээгдэж буй ерөнхий үр дүн:

- Аюулт үзэгдэл, ослын талаар ерөнхий ойлголттой болж, түүнээс урьдчилан сэргийлэх мэдлэгийг дээшлүүлэх
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндэсүүдийг мэдэх, үйл ажиллагаандаа ашиглаж сурах
- Аюулт үзэгдэл, ослоос хүн ам, эд хөрөнгө, хүрээлэн буй орчныг урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний мэдлэг, чадвар, хандлагыг дээшлүүлэх
- Аюулт үзэгдэл, ослын үед иргэдийн амь нас, улс, нийгмийн өмч хөрөнгийг аврах, хамгаалах арга ажиллагаанд тусгай чиг үүргийн бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх
- Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж буй тусгай чиг үүргийн бүлгүүдийн харилцан ажиллагааг сайжруулах, хамтын шийдвэр гаргах арга барилд суралцах
- Аюулт үзэгдэл, ослын голомтод эрэн хайх, аврах ажиллагаа явуулах мэдлэг, дадлага, чадвараа нэмэгдүүлэх
- Гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд тусгай чиг үүргийн бүлгүүд оролцох

Суралцахуйн зорилт	Хүлээгдэж буй үр дүн	Мэдлэг	Агуулга	Чадвар	Хандлага
Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндэс	Тусгай чиг үүргийн бүлгийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомж, Монгол Улсын гамшгаас хамгаалах тогтолцооны талаар ерөнхий ойлголт өгөх	Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Улсын нөөцийн тухай, Ойн тухай, Дайчилгааны тухай, Эрүүл мэндийн тухай хууль гэх мэт Ерөнхий зориулалтын болон Тусгай чиг үүргийн мэргэжлийн ангиудын гүйцэтгэх үүрэг болон харьяалах дээд шатны байгууллагатай холбоотой хууль Тусгай чиг үүргийн бүлгийн үйл ажиллагааны эрх зүйн орчин	Уг хуулиудыг судлан хуулиас тусгай чиг үүргийн бүлгийн үйл ажиллагаатай холбоотой зүйл заалтыг ашиглах чадвартай болох	Хуулийг өөрийн үйл ажиллагаанда ашиглаж сурах Холбогдолтой заалтыг ашиглах	

		“Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, бусад тусгай чиг үүргийн бүлгийн холбогдох төлөвлөгөө		
		Монгол Улсын гамшгаас хамгаалах тогтолцоо		
		Мэргэжлийн ангийн дүрэм, Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, Гал унтраах дүрэм, Нүүлгэн шилжүүлэх журам, “Нийтлэг журам батлах тухай” Шадар сайдын 2013 оны 52 дугаар тушаал, “Мал, амьтны гоц халдварт өвчний голомтод хээрийн мал эмнэлэг дэлгэн ажиллах заавар”, Тусгай цэвэрлэгээний бүлгийн ажиллах журам, Уснаас эрэн хайх, аврах ажиллагаа зохион байгуулах журам	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд мэргэжлийн дагуу зөвлөгөө, дэмжлэг, тусламж үзүүлж	Дүрэм журмыг үүрэг гүйцэтгэх үед ашиглах
		Холбогдох бусад дүрэм, журам		
	Тусгай чиг үүргийн бүлгийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам	Тусгай чиг үүргийн бүлгийн ангилал, бүтэц, үүрэг зориулалт, зохион байгуулалт, салбар, бүлгийн ажиллагаа, гамшгийн үед ажиллах аюулгүй ажиллагаа, мэргэжлийн ангид хөтлөгдөх баримт бичиг мэргэжлийн ангийн дүрэм	Аюулт үзэгдэл, ослын голомтод ажиллах үед бусад тусгай чиг үүргийн бүлэгтэй харилцан ажиллах Өөрийхөө болон бүлгийн аюулгүй байдлыг хангах Хөтлөгдөх баримт бичгийг хөтлөх	Мэргэжлийн дагуу нэрвэгдэгсдийг эрэн хайх, аврах
	Тусгай чиг үүргийн бүлгийн тухай			
	Цаг агаарын гаралтай аюулт үзэгдлийн тухай	Зуд, ган, цөлжилт, цасан болон шороон шуурга, үер, ой, хээрийн түймрийн талаар ерөнхий ойлголт өгөх	Аюулт үзэгдэл, ослын төрлүүдийг нэрлэж Тухай төрлөөс шалтгаалан авч хэрэгжүүлэх арга хэмжээг хийж	Тусгай чиг үүргийн бүлгийн үүргийг судлан гамшгийн төрлүүдэд
	Геологийн гаралтай аюулт үзэгдлийн тухай	Газар хөдлөлт, хөрсний гулсалтын талаар ерөнхий ойлголт өгөх		

<p>Аюулт үзэгдэл, ослын ойлголт тухай</p>	<p>Биологийн гаралтай үзэгдэлийн тухай аюулт</p>	<p>Олон улсын хөл өвчин, хорт шавьж, мэрэгчид тархах талаар ерөнхий ойлголт өгөх тухайн аюулт үзэгдэл, ослыг үед тусгай чиг үүргийн бүлгийноролцоо, гүйцэтгэх үүргийг судлуулах</p>	<p>урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах</p>	
<p>Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх</p>	<p>Төвлөлт, бэлэн байдал</p>	<p>Үйлдвэр, ахуйн осол, объектийн гал түймэр, зам, тээврийн осол, цацраг, химийн бодис тархах, дэлбэрэлтийн талаар онолын мэдлэг олгох, тухайн аюулт үзэгдэл, ослыг үед тусгай чиг үүргийн бүлгийн оролцоо, гүйцэтгэх үүргийг судлуулах</p> <p>Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед тусгай чиг үүргийн бүлгийн оролцоо, гүйцэтгэх үүргийг тодорхойлж таниулах</p> <p>Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгай чиг үүргийн бүлгийн гүйцэтгэх үүрэг</p> <p>Тусгай чиг үүргийн бүлэг, байгууллагын төлөвлөгөөнд бүлэг, хүн нэг бүрийн гүйцэтгэх үүрэг, харьцуулан ярилцах</p> <p>Бэлэн байх нь гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны салшгүй хэсэг болох тухай, хүн нэг бүр, бүлэг, тусгай чиг үүргийн бүлгийн бэлэн байдлын хангах талаар таниулах, хүн нэг бүрд байх зүйлсийн жагсаалтыг танилцуулах, бэлэн байдлын үзлэг явуулах, үүргэвчийг жигдрүүлэх</p> <p>Хүн, аврах багаж хэрэгслийн нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах</p> <p>Харилцаа холбооны бэлэн байдлын талаар тайлбарлах</p>	<p>Бэлэн зэргүүд, ажлуудыг нэрлэх Өөрийн байдлыг хангаж Нөөц, болон хүн нэг бүрийн үүргэвчинд байх зүйлийг нэрлэж</p>	<p>Аюулт үзэгдэл, ослын ажиллах бэлтгэл, бэлэн байдлаа хангах</p>
<p>Гамшгийн эрсдэл бууруулах</p>	<p>Гамшгийн эрсдэл бууруулах</p>	<p>Гамшгийн эрсдэл бууруулах эрсдэлийн үнэлгээний тухай ойлголт өгөх, аюулт үзэгдэл, ослын учруулж болзошгүй хохирлыг үнэлэх,</p>	<p>Гамшгийн эрсдэлийг SWOT шинжилгээний аргаар тооцож</p>	<p>Тохиолдож болзошгүй аюулт үзэгдэл,</p>

		явал хохирол багатай давах талаар танилцуулах, ярилцах		ослын эрсдэлийг тооцсоны үндсэнд эмзэг байдлыг бууруулах
Гамшгаас хамгаалах сургалт	Сургалтын ангилал, төрөл, иж бүрэн болон удирдах бүрэлдэхүүний сургалтын тухай, тусгай чиг үүргийн бүлгийн оролцооны талаар ярилцах, дадлага хийх Тусгай чиг үүргийн бүлгийн бүрэлдэхүүнээс иргэд, аж ахуйн нэгж байгууллагад сургалт явуулах талаар танилцуулах	Гамшгаас хамгаалах сургалтын ангилал, сургалт явуулах аргыг нэрлэх	Сургалтын төрлүүд, тусгай чиг үүргийн бүлгийн сургалтын онцлогыг ашиглаж сургалт явуулах	
Урьдчилан сэргийлэх хяналт	Урьдчилан сэргийлэх хяналтыг тусгай чиг үүргийн бүлгийн бүрэлдэхүүн өөрийг гүйцэтгэх үүрэг, чиглэлийн дагуу явуулж байх, хяналт явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хяналтын төрлийн талаар ойлголт өгөх	Гамшгаас хамгаалах хяналтыг хаанаас хэн явуулдагийг нэрлэх	Өөрийн гүйцэтгэх үүрэг, мэргэжлийн чиглэлийн дагуу хяналт явуулах	
Мэдээлэл, сурталчилгаа	Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлэг хүргэх, ухуулга сурталчилгаа явуулах арга, хэлбэр, иргэдэд хүргэх талаар тайлбарлах	Болзошгүй аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг хэрхэн явуулдагийг нэрлэх	Урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг, ухуулга сурталчилгааг явуулах	
Эрэн хайх, аврах ажиллагааны үндсэн ойлголт, голломтод эрэн хайх, аврах	Гамшгийн төрөл, учруулах хор уршиг, тэдгээрээс хамгаалах, аврах ажил; Бүх төрлийн аврах ажил явуулах үндэс; Аврах анги, отряд, салбар, тусгай чиг үүргийн бүлгийн аврах ажил явуулах боломж, аврах	Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгийг урьдчилан сэргийлэх, аврах, учирсан хор уршгийг шуурхай	Эрэн хайх, аврах ажлыг мэргэжлийн ангийн төрөл, үүргээс	

	<p>ажиллагаа явуулах</p>	<p>ажлын журам, даргалал Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлага Өөр өөрийн мэргэшлийн дагуу аврах ажил явуулах онол, дэдлагын мэдлэгтэй байх;</p> <p>Радио холбооны үндэс, аврах ажил явуулах үед хэрэглэдэг олон улсын дохионууд болон гамшгаас хамгаалах дохионуудтэдгээрээр ажиллаж журам</p>	<p>арилгах ажиллагааны үед цагийн байдлыг үнэлж, шийдвэр гарган эрэн хайх, аврах хамгаалах болон хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэж, Аврах багаж, техник хэрэгслийн бүтэц, зохион байгуулалт, зориулалт, техникийн өгөгдөхүүн, ажиллагааны зарчмыг нэрлэж Өөртөө болон нэрвэгдэгсдэд эмнэлгийн анхны тусламж үзүүлж; Гамшгийн үед холбоо зохион байгуулж; Гамшиг тохиолдсон газар оронд байр зүйн баримжаалал, тагнуул, туршуул зохион байгуулах</p>	<p>шалтгаалан бие дааж гүйцэтгэх, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын амь нас, эд хөрөнгийг аврах, хамгаалах</p>
<p>Аврах багаж хэрэгслийн ашиглалт хадгалалт, хүчин чадал</p>	<p>Гадаад улс орнуудын ижил төстэй байгууллагын аврах техник, багаж хэрэгслийг судлах Онцгой байдлын албанд ашиглаж байгаа эрэн хайх, аврах, хамгаалах багаж хэрэгслүүдийг ашиглах, тэдгээрийн техникийн хүчин чадал,</p>	<p>Эрэн хайх, аврах, хамгаалах багаж хэрэгслүүдийн өгөгдөхүүн, зориулалтыг нэрлэх</p>	<p>Багаж хэрэгслийг ашиглан аврах ажиллагаа явуулах</p>	

	<p>өгөгдөхүүн, ажиллагаа, хадгалалт Тусгай чиг үүргийн бүлэгт ашиглаж байгаа аврах техник, багаж хэрэгслийн ашиглалт хадгалалт, техникийн өгөгдхүүн</p>	<p>Аврах ажиллагааг явуулах зааврыг нэг бүрчлэн нэрлэж чадах</p>	<p>Өөрийгөө эрсдэлгүй бусдыг аврах</p>
<p>Эрэн хайх, аврах ажиллагаа явуулах үеийн аюулгүй аюулгүй ажиглалтаа</p>	<p>Эрэн хайх, аврах ажиллагаа явуулах үеийн аюулгүй ажиллагаа, гал унтраах дүрэм аюулгүйн зааварчилгаа</p>	<p>Дохио дамжуулах, хүлээн авах, эргэж мэдэгдэх Зарлан мэдээллийн дохионуудыг нэрлэж</p>	<p>Аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд зөвлөгөө, дэмжлэг, тусламж үзүүлэх</p>
<p>Зарлан мэдээллийн дохио хүргэх дамжуулах, дохиогоор ажиллах журам</p>	<p>Зарлан мэдээллийн дохио хүргэх дамжуулах, дохиогоор ажиллах журам</p>	<p>Хээрийн штабт бие даан болон бүлэг, ангийн бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэж</p>	<p>Аврах, сэргээн босгох ажил явуулах</p>
<p>Шуурхай штаб, онцгой комиссын ажиглалаа, хээрийн штаб байгуулах</p>	<p>Шуурхай штаб байгуулах Штабын бүрэлдэхүүн Хээрийн штабын ажиллагаа</p>	<p>Эрэн хайх, аврах хүч хэрэгслийн үүрэг гүйцэтгэх боломжийг тооцож Гамшгийн төрлөөс шалтгаалан өөрийн тусгай чиг үүргийн бүлгийн үүргийг нэрлэх</p>	<p>Тухайн төрлийн аюулт үзэгдэл, ослын үед бусад бүлэг, ангиудтай хамтран ажиллах</p>
<p>Аврах үйл ажиллагааны үүрэг хариуцлагын хуваарилалт, мэргэжлийн ангиудын оролцоо</p>	<p>Тусгай чиг үүргийн бүлгийн аврах үйл ажиллагааны боломж Хүч хэрэгслийн тооцоо Бусад тусгай чиг үүргийн бүлэгтэй харилцан ажиллах</p>	<p>Бүх төрлийн эрэн хайх, аврах ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд явуулж</p>	<p>Мэргэжлийн чадвараа ашиглан аврах ажиллагаа явуулах</p>
<p>Голомтод эрэн хайх, аврах ажиллагаа явуулах</p>	<p>Голомтод эрэн хайх аврах ажиллагаа явуулах дараалал Эрэн хайх аврах ажиллагааны журам, төрөл</p>		

Гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох	Хорио цээрийн дэглэм сахиулах Гамшгийн үеийн харилцан ажиллагаа, хамтран ажиллах	Хүн малд хор хөвдөл учруулах нөхцөл бий болсон үед түүнээс сэргийлэх, гарсан үр дагаварыг арилгах Халдвар тархалтыг сааруулах Хорио дэглэм тогтоох, сахиулах ажиллагааны журам, дэс дараалал, мэргэжлийн ангийн үүрэг, ажиллагаа Харилцан ажиллах журам, боломж, харилцан ажиллагааны төлөвлөгөө тусгай чиг үүргийн бүлгүүдийн хоорондын, тусгай чиг үүргийн бүлэг, аврах анги, салбарын хоорондын харилцаа, хамтын ажиллагаа, харилцан ажиллах боломж, өөрийн үүрэг	Хорио дэглэм нөхцлийг нэрлэх Харилцан болон хамгаалах төлөвлөгөөнд заагдсан мэргэжлийн бүлэг, өөрийн үүргийг нэрлэж	Халдварын тархалтыг зогсоох Бусад мэргэжлийн анги, аврах ангитай харилцан аврах сэргээн босгох ажиллагааг явуулах
Гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох	Гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох	Аюулт үзэгдэл, ослын хор уршгийг арилгах Сэргээн босгох ажиллагаа явуулах тухай, /нэн яаралтай сэргээн босголт, дунд хугацааны сэргээн босголт, урт хугацааны сэргээн босголт/ мэргэжлийн ангийн оролцоо Хохирлын тооцоо, үнэлгээ явуулах	Нэн яаралтай авч хэрэгжүүлэх болон эхний ээлжинд хийгдэх ажлуудыг танилцуулах Хор уршгийг арилгах, сэргээн босгох	Эхний ээлжинд хэрэгжүүлэх ажиллагааны санал боловсруулах, сэргээн босгох Сэтгэл зүйн
Хангалтын төрөл, хангалт явуулах	Хангалтын төрөл, хаанаас ямар хангалт явуулдагийг нэрлэх	Хангалт явуулдаг мэргэжлийн ангилуд Хангалтын төрөл Гамшгийн үед хангалт зохион байгуулах журам	Хангалтын төрөл, хаанаас ямар хангалт явуулдагийг нэрлэх	Бүх төрлийн хангалтаар хангагдах
Гамшгийн голомтоос нүүлгэн шилжүүлэх, хүч хэрэгсэл дайчлах	Гамшгийн голомтоос нүүлгэн шилжүүлэх, хүч хэрэгсэл дайчлах	"Гамшгийн голомтоос нүүлгэн шилжүүлэх, хүч хэрэгсэл дайчлах журам" Засгийн газрын 2012 оны 340 дүгээр тогтоол	Нүүлгэн нөхцөл, нэрлэх Нүүлгэн шилжүүлэх, дайчлах ажиллагааг	Нүүлгэн шилжүүлэх үед ажиллах Дайчилгаа явуулах эрх үүрэг

		Аврагч болон нэрвэгдэгсдийн сэтгэл зүйг сэргээх	ажиллагааны нэрлэх Хохирлын мэргэжлийн хэмжээнд хийж Гамшгийн нэрвэгдэгсдийн сэтгэл зүйн үйлчилгээ явуулж тайвшруулах	тусламж үзүүлэх
--	--	---	---	-----------------

**ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН БҮЛГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ МЭДЛЭГ,
ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН СЭДЭВЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Агуулга	Сэдэв	Сургалт зохион байгуулах хэлбэр, цаг				Хариуцах байгууллага
			лекц	семинар	case study	Нийт	
Сургалтын агуулгын төрөл: Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндэс (7 цаг)							
1	Хууль, тогтоомж	Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Улсын нөөцийн тухай хууль	2			2	ОБА, Мэргэжлийн н ангийн дарга
	Дүрэм журам, эрх зүйн акт	Мэргэжлийн ангийн дүрэм	1			1	
		Гамшгийн голомтоос нүүлгэн шилжүүлэх, хүч хэрэгсэл дайчлах журам	1		2	3	
		Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм	1			1	
			5	2	7		
Буга							
Сургалтын үндэстэй төгөлдөг үзүүлэлтүүдийн төлөвлөгөө							
2	Цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл	Зуд, ган, цөлжилт, цасан болон шороон шуурга, үер, ой, хээрийн түймэр	2			2	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга

	Геологийн гаралтай аюулт үзэгдэл	Газар хөдлөлт, хөрсний гулсалт	1		1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
	Биологийн гаралтай аюулт үзэгдэл	Хүний гоц халдварт өвчин, Малын гоц халдварт өвчин, Хорт шавьж, мэрэгчид тархах	1		1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
	Технологийн гаралтай осол	Үйлдвэрийн осол, Объектийн гал түймэр, Зам, тээврийн осол, Цацраг, химийн бодис тархах, Дэлбэрэлт	1		1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
	Нийгмийн гаралтай аюул	Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал	1		1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
		Бүгд	6		6	
3	Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх	Телевлөлт, бэлэн байдал Гамшгийн эрсдэл бууруулах Гамшгаас хамгаалах сургалт Урьдчилан сэргийлэх хяналт Сурталчилгаа, мэдээлэл	1 1 1 1 1		1 1 8 1 1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
		Бүгд	5		8	13
4	Эрэн хайх, аврах ажиллагаа	Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэг, зэрэгт шилжсэн үед хэрэгжүүлэх арга хэмжээ Эрэн хайх, аврах ажиллагааны үндсэн ойлголт, голомтод эрэн хайх, аврах ажиллагаа явуулах Аврах техник, багаж хэрэглийн ашиглалт хадгалалт, техникийн өгөгдөхүүнийг судлах Эрэн хайх, аврах ажиллагаа явуулах үеийн аюулгүй ажиллагаа	1 1 1 1		1 1 1 1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга

ЭРҮҮЛ МЭНДИЙН АЛБАН ХААРЬЯА /Эмнэлгийн яаралт/ тусламжийн, Хээрийн эмнэлэг, С сэлбэх хөдөлгөөнт, Хөдөлгөөнт эмийн сан, Эмнэлэг эрүүл ахуй, Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх/ ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН БҮЛГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ МЭДЛЭГ, ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН СЭДЭВЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Агуулга	Сэдэв	Сургалт зохион байгуулах хэлбэр, цаг				Хариуцах байгууллага
			лекц	семинар	case study	Нийт	
Сургалтын агуулгын төрөл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндэс (7 цаг)							
1	Хууль, тогтоомж	Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Улсын нөөцийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж	1			1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
	Дүрэм журам, эрх зүйн акт	Мэргэжлийн ангийн дүрэм Эрүүл мэндийн тусгай чиг үүргийн бүлэгтэй холбоотой удирдлагын баримт бичиг	1		4	5	
			1			1	
			3		4	7	
Бүгд							
2	Цаг агаар, геологийн гаралтай аюулт үзэгдэл	Зуд, ган, цөлжилт, цасан болон шороон шуурга, үер, ой, хээрийн түймэр, газар хөдлөлт, хөрсний гулсалт, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, дэлбэрэлт	1			1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
	Биологи, технологийн нийгмийн гаралтай аюул	Олон улсын хөл хориот өвчин, хортон шавьж, мэрэгчид тархах, үйлдвэрийн осол, объектийн гал түймэр, зам, тээврийн осол, цацраг, химийн бодис тархах	1		4	5	
			2		4	6	
			2		4	6	
Бүгд							
3	Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх	Төлөвлөлт, бэлэн байдал, сурталчилгаа, мэдээлэл Гамшгийн эрсдэл бууруулах, гамшгаас хамгаалах сургалт, урьдчилан сэргийлэх хяналт	1		2	3	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
			1		6	7	
			2		8	10	
			2		8	10	
Бүгд							

		1	2	3				
4	Эрэн хайх, аврах ажиллагаа	Зарлан мэдээллийн дохио хүргэх дамжуулах, дохиогоор ажиллах	1	2	3	ОБА, Эрүүл мэндийн алба, тусгай чиг үүргийн бүлгийн дарга		
		Нэрвэгдэгсдэд үзүүлэх эмнэлгийн анхны тусламж	1	4	5			
		Эрэн хайх, аврах ажиллагаа явуулах үеийн аюулгүй ажиллагаа	1		1			
		Халдварын шинжилгээ явуулах	1	2	3			
		Нэрвэгдэгсдэд үзүүлэх ариун цэвэр, эрүүл ахуй, халдвар эсэргүүцэх хяналт	1	2	3			
		Аврах үйл ажиллагааны үүрэг хариуцлагын гуваарилалт, тусгай чиг үүргийн бүлгүүдийн оролцоо, харилцан ажиллагаа	1	2	3			
		Хорио цээрийн дэглэм тогтоох, сахиулах, хээрийн эмнэлэг дэлгэн ажиллуулах	1	4	5			
		Эмнэлгийн хангалтын төрөл, хангалт явуулах журмын тухай	1		1			
		Цус, цусан бүтээгдэхүүнийг нөөцлөх, хангах, тээвэрлэх, эм, эмнэлгийн бүтээгдэхүүнээр хангах	1		1			
		Эмнэлгийн анхны тусламжийн багаж хэрэгсэл, нэг бүрийн хэрэгсэл	1	2	3			
		Нэрвэгдэгсдэд сэтгэл зүйн дэмжлэг, тусалцаа үзүүлэх	1	4	5			
		Бүгд		11	22		33	
		5	Гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох	Бүгд				
Аюулт үзэгдэл, ослын хор уршгийг арилгах	1				1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга		
Сэргээн босгох ажиллагаа явуулах, тусгай чиг үүргийн бүлгүүдийн оролцоо	1			4	5			
Хохирлын тооцоо, үнэлгээ	1				1			
Бүгд		3	4	7				
НИЙТ		20	47	83				

ХҮҮХЭД, ӨНДӨР НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЭЙ ИРГЭДИЙГ ХАМГААЛАХ ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН БҮЛГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ МЭДЛЭГ, ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН СЭДЭВЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/Д	Агуулга	Сэдэв	Сургалт зохион байгуулах хэлбэр, цаг				Хариуцах байгууллага
			лекц	семинар	татлага	Нийт	
Сургалтын агуулгын төрөл: Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндэс (1 цаг)							
1	Хууль, тогтоомж	Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Нийгмийн халамжийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль	1			1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
Бүгд							
			1			1	
2	Цаг агаар, геологийн гаралтай аюулт үзэгдэл Биологи, технологийн нийгмийн гаралтай аюул	Зуд, ган, цөлжилт, цасан болон шороон шуурга, үер, ой, хээрийн түймэр, газар хөдлөлт, хөрсний гулсалт, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, дэлбэрэлт Олон улсын хөл хориот өвчин, хортон шавьж, мэргэгчид тархах, үйлдвэрийн осол, объектийн гал түймэр, зам, тээврийн осол, цацраг, химийн бодис тархах	1			1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
Бүгд							
			2			2	
3	Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх	Болзошгүй аюулт үзэгдэл, ослоос, хүүхэд, өндөр настныг урьдчилан сэргийлэх, хамгаалах Гамшгийн эрсдэл бууруулах, хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй явуулах сургалт	1		2	3	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
Бүгд							
			2		6	7	
			2		8	10	
4	Эрэн хайх, аврах ажиллагаа	Хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зарлан мэдээллийн дохио хүргэх, дамжуулах	1		2	3	

	Хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эмнэлгийн анхны тусламж	1	4	5	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
	Аюулт үзэгдэл ослын үед хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрэн хайх, аврах ажиллагаа явуулах онцлог	1		1	
	Хорио цээрийн дэглэм тогтоох, сахиулах үеийн хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамгаалал	1	2	3	
	Хямралын үеийн хүүхэд хамгаалал	1		1	
	Хямралт байдлын үед өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, нийгмийн халамж үзүүлэх	1		1	
	Нэрвэгдэгсдэд сэтгэл зүйн дэмжлэг, тусалцаа үзүүлэх	1	2	3	
Бүгд		7	10	17	
5	Гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох	1		1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
	Нүүлгэн шилжүүлэх, байрлуулах үед үеийн хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах, дэмжлэг тусалцаа үзүүлэх	1	4	5	
Бүгд		2	4	6	

ГАЛ УНТРААХ ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН БҮЛГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ МЭДЛЭГ, ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН СЭДЭВЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

А/А	Агуулга	Сэдэв	Сургалт зохион байгуулах хэлбэр, цаг			Хариуцах байгууллага
			лекц	Семинар	дартлага	

Сургалтын агуулгын төрөл Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндэс (7 цаг)						
1	Хууль, тогтоомж	Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Улсын нөөцийн тухай хууль	1		1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
	Дүрэм журам, эрх зүйн акт	Мэргэжлийн ангийн дүрэм	1		1	
		Гал унтраах дүрэм, Хорт хийн утаанаас хамгаалах дүрэм	1	4	5	
Бүгд						
Сургалтын агуулгын төрөл Аюулгүй байдлын тухай хууль, Улсын нөөцийн тухай хууль						
2	Цаг агаар, геологийн гаралтай аюулт үзэгдэл	Ой, хээрийн түймэр, газар хөдлөлт, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, дэлбэрэлт	1	2	3	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
	Биологи, технологи, нийгмийн гаралтай аюул	Үйлдвэрийн осол, объектийн гал түймэр, зам, тээврийн осол	1	2	3	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
Бүгд						
Сургалтын агуулгын төрөл Аюулгүй байдлын тухай хууль, Улсын нөөцийн тухай хууль						
3	Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх	1		1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
		Объектийн гал түймрээс урьдчилан сэргийлэх хяналт	1		1	
Бүгд						
Сургалтын агуулгын төрөл Гал, тухайн үйлдвэр, ажлаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндэс (7 цаг)						
4	Эрэн хайх, аврах ажиллагаа	Гал түймэр, шатлагын тухай үндсэн ойлголт	1		1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
		Гал түймрийн үед хэрэглэх эрэн хайх, аврах, хамгаалах багаж хэрэгслүүдийг ашиглах, тэдгээрийн техникийн хүчин чадал, өгөгдөхүүн, ажиллагаа, хадгалалт	1	4	5	
		Галын дуудлагаар очих, галын хайгуулын төрөл, гүйцэтгэх үүрэг	1	6	7	
		Гал түймрийн голомтод эрэн хайх, аврах үеийн аюулгүй ажиллагаа	1	2	3	
		Объектийн гал түймэр унтраах ажиллагаа, тархалтын төрлүүд	1	8	9	
	Ой, хээрийн түймрийн тархалтад нөлөөлөх үндсэн хүчин зүйл	1		1		

	Ой, хээрийн түймэр унтраа, гарга ажиллагаа, аврагч-гал сөнөөгчийн гүйцэтгэх үүрэг	1	8	9	
	Гал түймрийн үед иргэд, аж ахуйн нэгжийн эд хөрөнгийг хамгаалах, амь насыг аврах	1	2	3	
	Нэрвэгдэгсдэд үзүүлэх эмнэлгийн анхны тусламж, сэтгэл зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх	1	4	5	
	Бүгд	9	34	43	
	Сургалтын агуулгын төрөл, Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндэс (1 цаг)				
5	Гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох	1		1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
	Гал түймрийн голомтоос нүүлгэн шилжүүлэх	1	4	5	
	Нэмэлт хүч хэрэгсэл дайчлах	1		1	
	Бүгд	3	4	7	
	НИЙТ	19	48	57	

ДУЛААНЫ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ЗАСВАРЫН ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН БҮЛГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ МЭДЛЭГ, ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН ЦАГИЙН ТООЦОО

Д/Д	Агуулга	Сэдэв	Сургалт зохион байгуулах хэлбэр, цаг			Хариуцах байгууллага
			Лекц	Семинар	Нийт	
	Сургалтын агуулгын төрөл: Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндэс (1 цаг)					
1	Эрх зүйн зохицуулалт	Дулааны шугам сүлжээний засварын тусгай чиг үүргийн бүлгийн үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомж, дүрэм, журам, эрх зүйн акт	1		1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
	Бүгд		1		1	
	Сургалтын агуулгын төрөл: Хөдөлгөөн урьдчилан сэргийлэх ажиллагаа					
2	Урьдчилан сэргийлэх ажиллагаа	Хөдөлгөөн урьдчилан сэргийлэх ажиллагаа	1	2	3	
	Бүгд		1	2	3	

		Сургалтын агуулгын төрөл, Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төрөл		1	1	1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
3	Эрэн хайх, аврах ажиллагаа	Аюул, ослын үеийн дулааны шугам сүлжээний засварын тусгай чиг үүргийн бүлгийн ажиллагаа		1	4	5	
		Дулааны шугам сүлжээний засварын тусгай чиг үүргийн бүлгийн хэрэглэх багаж хэрэгслүүд		1	6	7	
		Дулааны шугам сүлжээний засварын тусгай чиг үүргийн бүлгийн аврах ажиллагаа явуулах үүрэг, оролцоо		1	2	3	
		Бүлгийн гишүүдийн ажиллагаа		1	8	9	
		Бусад мэргэжлийн ангиудтай гамшгийн үед харилцан ажиллах		1	20	25	
		Бүгд		5			
		Сургалтын агуулгын төрөл, Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төрөл		1	4	5	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
4	Гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох	Дулааны шугам сүлжээний аваар техникийн бүлгийн хор уршгийг арилгах сэргээн босгох ажиллагааны үед хийгдэх ажлууд		1	4	5	
		Бүгд		1	4	5	

ЦЭВЭР, БОХИР УСНЫ ЗАСВАРЫН ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН БҮЛГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ МЭДЛЭГ, ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН ЦАГИЙН ТООЦОО

Д/Д	Агуулга	Сэдэв	Сургалт зохион байгуулах хэлбэр, цаг			Хариуцах байгууллага
			Лекц	Семинар	Татгалз	
Сургалтын агуулгын төрөл, Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндэс (1 цаг)						
1	Эрх зүйн зохицуулалт	Хууль, тогтоомж, дүрэм журам, эрх зүйн акт	1		1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
		Бүгд		1	1	

2	Урьдчилан сэргийлэх ажиллагаа	Уст цэг, цэвэр бохир усны шугам хойлог хамгаалах	1		1	
			1		1	
Бүгд						
Сургалтын зориулалтын үнэмлэхүй үнэ						
		Аюул, ослын үеийн цэвэр, бохир усны засварын тусгай чиг үүргийн бүлгийн ажиллагаа	1		1	
		Цэвэр, бохир усны засварын тусгай чиг үүргийн бүлгийн хэрэглэх багаж хэрэгслүүд	1	2	3	
	Эрэн хайх, аврах ажиллагаа	Цэвэр, бохир усны засварын тусгай чиг үүргийн бүлгийн аврах ажиллагаа явуулах үүрэг, оролцоо	1	4	5	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
		Байгалийн болон гадаад орчны бохирдлоос ус, усны эх булгийг хамгаалах	1	2	3	
		Байгалийн болон гадаад орчны бохирдлоос ус, усны эх булгаас дээж авч шинжлүүлэх	1	2	3	
Бүгд						
Сургалтын зориулалтын үнэмлэхүй үнэ						
	Гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох	Цэвэр, бохир усны засварын тусгай чиг үүргийн бүлгийнхор уршгийг арилгах сэргээн босгох ажиллагааны үед хийгдэх ажлууд	1	4	5	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
Бүгд						
Нийт						
			5	10	15	

ЦАХИЛГААНЫ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ЗАСВАРЫН ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН БҮЛГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ МЭДЛЭГ, ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН ЦАГИЙН ТООЦОО

д/д	Агуулга	Сэдэв	Сургалт зохион байгуулах хэлбэр, цаг				Хариуцах байгууллага
			лекц	семинар	дартла	Нийт	

Сургаальны агуулгын төрөл: Гамшгаа хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндэс (1 цаг)						
1	Эрх зүйн зохицуулалт	Цахилгаан шугам сүлжээний засварын тусгай чиг үүргийн бүлгийн аврах, сэргээн босгох ажиллагаа явуулах эрх зүйн орчны тухай	1		1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
Бүгд						
Сургалтын агуулгын төрөл: Урьдчилан сэргийлэх ажиллагаа						
2	Урьдчилан сэргийлэх ажиллагаа	Цахилгаан эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээг аюулт үзэгдэл, ослоос хамгаалах	1	2	3	
Бүгд						
Сургалтын агуулгын төрөл: Эрэн хайх, аврах ажиллагаа (12 цаг)						
3	Эрэн хайх, аврах ажиллагаа	Аюул, ослын үеийн цахилгаан шугам сүлжээний засварын тусгай чиг үүргийн бүлгийн ажиллагаа	1		1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
		Цахилгаан шугам сүлжээний засварын тусгай чиг үүргийн бүлгийн гамшгийн үед гүйцэтгэх үүрэг	1	4	5	
		Цахилгаан шугам сүлжээний засварын тусгай чиг үүргийн бүлгийн хэрэглэх багажхэрэгслүүд	1	2	3	
		Цахилгаан шугам сүлжээний засварын тусгай чиг үүргийн бүлэгаврах, сэргээн босгох ажиллагаа явуулах	1	2	3	
		Бүгд	4	8	12	
Сургалтын агуулгын төрөл: Гамшгаа хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндэс (5 цаг)						
4	Гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох	Цахилгаан шугам сүлжээний засварын тусгай чиг үүргийн бүлгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагааны үед хийгдэх ажлууд	1	4	5	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
Бүгд						
НИЙТ						
			7	14	21	

ЗАМ ГҮҮРИЙН ЗАСВАР, ХӨНЖИНЕР ТЭСЭЛГЭЭНИЙ ТӨСГӨЙ ЧИГ ҮҮРГИЙН БҮЛГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ МЭДЛЭГ,
 ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН ЦАГИЙН ТООЦОО

Д/Д	Агуулга	Сэдэв	Сургалт зохион байгуулах хэлбэр, цаг			Хариуцах байгууллага	
			лекц	seminar	дартлага		Нийт
Сургалтын агуулгын төрөл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндэс (1 цаг)							
1	Эрх зүйн зохицуулалт	Тусгай чиг үүргийн бүлгийн аврах, сэргээн босгох ажиллагаа явуулах эрх зүйн орчин	1			1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
Бүгд							
Сургалтын агуулгын төрөл. Хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндэс (3 цаг)							
2	Урьдчилан сэргийлэх ажиллагаа	Тусгай чиг үүргийн бүлгийн гамшгаас урьдчилан сэргийлэх ажиллагаа	1	2		3	
Бүгд							
Сургалтын агуулгын төрөл. Эргэлт, өөрчлөлт, шинэчлэл							
3	Эрэн хайх, аврах ажиллагаа	Аюул, ослын үеийн мэргэжлийн ангийн ажиллах ажиллагаа	1			1	ОБА, тусгай чиг үүргийн бүлгийн дарга
		Тусгай чиг үүргийн бүлгүүдийн гамшгийн үед гүйцэтгэх үүрэг	1	4		5	
		Тусгай чиг үүргийн бүлэгт хэрэглэгдэх аврах техник, багаж хэрэгсэлүүд	1	2		3	
